



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/02

Мандалговь

Үндэсний дээл хувцсаа өмсөж,
Монгол хэл бичигт суралцах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дахь заалт, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16.1.1 дахь заалт, Дундговь аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн А/02 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол үндэсний бахархал болсон өв соёлоо түгээн дэлгэрүүлж, Монгол соёлын дархлааг бий болгох зорилгоор үндэсний дээл хувцсаа сар бүрийн 3 дахь долоо хоногийн лхагва гаригт өмсөж хэвшин, монгол бичгийн сургалт, уншлагын цагт идэвхтэй хамрагдахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

2. Үндэсний дээл хувцсаа өмсөж, үндэсний бичиг үсэгт суралцах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батхүү)-д даалгасугай.

ДАРГА



Н.ГАНТУЛГА